



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/76

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн 3 дугаар багт хогийн төвлөрсөн цэг шинээр барих ажлыг Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээний компаниар гүйцэтгүүлсүгэй.
2. Тохижилт үйлчилгээний компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.
3. Хогийн төвлөрсөн цэг шинээр барих ажилд шаардагдах 9985000 (Есөн сая есөн зуун наян таван мянган) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Б.Мажигдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМБЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010751